

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАДНА ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ЗОРИЛГООР АШИГЛАЖ БАЙГАА ДҮРС БИЧЛЭГИЙН ТЕХНИК, ХЭРЭГСЛИЙГ
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭНД ХОЛБОХ
ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээ /Цаашид “теле хяналтын нэгдсэн сүлжээ” гэх/-нд холбох харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

1.3.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дордурдсан утгааройлгоно:

“Барилга байгууламж” - Барилгын тухай хуулийн 4.1.1-д зааснаар

“Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл” - нэгдсэн системд холбогдсон, эсхүл нэг бүрийн зориулалттай, хууль сахиулах ажиллагаанд шаардлагатай нотлох баримт болох дууны, дүрсний, дуу-дүрсний мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин хэрэгслийг;

“Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээ” - 24 цагаар тасралтгүй ажиллах, цагдаагийн байгууллага, алба хаагчийн албаны компьютерн цагдаагийн байгууллагын сервер компьютерт ханд алтхийх боломжтой байхаар байгуулсан сүлжээг;

“Мэдээллийн аюулгүй байдал” – мэдээлэл, өгөгдөл, түүнийг дэмжих дэд бүтцийн хамгаалагдсан байдал;

“Мэдээллийн нууцлал, хамгаалал” – мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн системийн нүйл ажиллагааг тасалдуулах, хянахаас хамгаалах;

“Эрх бүхий алба хаагч” – цагдаагийн алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн багууллагын дарга, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 29 дүгээр зүйлд заасан эрх хэмжээг хэрэгжүүлж буй болон захиргааны зөрчил шалгах эрх бүхий алба хаагчийг;

“Нэндаруй” - 24 цагийн дотор буюу уугажиллагааг биелүүлэх боломжтой хамгийн богино хугацааг;

“Тэрдаруй” - тухайнажиллагаа эхэлмэгц, эсвэл дуусмагц дараагийн ажиллагааг хийж эхлэхийг болон дуусгахыг шаардсан хугацааг;

“Хандалт”

цагдаагийнбайгууллагыннэгдсэнсүлжээашигланцахиммэдээллийнсан,
програмангамжиднэвтрэхүйлажиллагааг;

“Дэдсүлжээ” – бие даасан өөрийн сүлжээний тоног төхөөрөмж, кабель, монтажийг;

“Гэмт хэрэгтэй тэмцэх” - Цагдаагийн албаны тухай хуулийн 3.1.1-д зааснаар;

“Нийтийн хэв журам хамгаалах” - Цагдаагийн албаны тухай хуулийн 3.1.2-д зааснаар;

“Олон нийтийн аюулгүй байдлыг хангах” - Цагдаагийн албаны тухай хуулийн 3.1.3-д зааснаар.

Хоёр. Дүрс бичлэгийн техник, хэрэгсэлд тавигдах шаардлага

2.1.Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.4-т заасан стандарт болон Олон улсын IP67 стандарт”-д нийцэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.шилэн кабелийн холболтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагад холболт хийгдсэн, бие даасан дэд сүлжээ, техникийн өрөөтэй байх;

2.1.2.дүрсний нягтаршилHD1080 Мегапикселээс багагүйбайх;

2.1.3.харанхуйд бичлэг хийх чадвартай байх;

2.1.4.төхөөрөмж нь нэг секундэд 24 болон түүнээс дээш /frame /зураг авах, дууг 128 bitrate /kb/s/ болон түүнээс дээш үзүүлэлтээр бичлэг хийх боломжтой байх;

2.1.5.хүний царай зүс, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;

2.1.6.нэгдсэн системд холбогдсон төхөөрөмж нь 168, нэг бүрийн төхөөрөмж нь 72 цагаас багагүй хугацаанд мэдээллийг хадгалах багтаамжтай байх;

2.1.7.газар хөдлөлтийн 8 баллд болон -40⁰С-ээс +40⁰С хэмд тэсвэртэй байх;

2.1.8.камер, бичлэгийн төхөөрөмжийн тохиргооны горим нь англи болон монгол хэлтэй байх;

2.1.9.шилэн кабелийн сүлжээний хурд нь хандалт хийх камерыг хамгийн багадаа HD720 Мегапиксел дүрсний нягтралаар харах нөхцлийг хангасан байх;

2.1.10.тоон технологид суурилсан /IP/ камерын систем нь сүлжээний хаягжилт хийж, тохируулах боломжтой байх;

2.1.11.мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангасан байх.

Гурав.Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбох

3.1.Цагдаагийн төв байгууллагын Мэдээллийн технологи, холбооны нэгж нь барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбоход дор дурдсан эрх үүрэгтэй:

3.1.1.дүрс бичлэгийн техник, хэрэгслийг теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбоход ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

3.1.2.теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбогдсон барилга байгууламжийн дотоод сүлжээний төхөөрөмжийн хаягжилтыг өөрчлөх, тохируулах;

3.1.3.энэ журмын 2.1 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах талаар барилга байгууламжийг эзэмшиж, өмчилж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /Цаашид “этгээд” гэх/-д шаардлага тавих.

3.2.Барилга байгууламжийг эзэмшиж, өмчилж байгаа этгээд дор дурдсан үүрэгтэй:

3.2.1.энэ журмын 2.1 дүгээр зүйлд заасан шаардлагыг бүрэн биелүүлэх;

3.2.2.цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх, хамтран ажиллах;

3.2.3.барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн аюулгүй байдал, засвар үйлчилгээ бусад холбогдох зардлыг хариуцах;

3.2.4.дүрс бичлэгийн техник, хэрэгсэл гэмтэх, эвдрэх, ашиглалтын шаардлага хангахгүй тохиолдолд нэн даруй засах, солих.

3.3.Барилга байгууламжийг эзэмшиж, өмчилж байгаа этгээд сүлжээнд холбогдсон тоног төхөөрөмжийн цахилгаан тэжээлийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангана.

Дөрөв. Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг хэрэглэх, хориглох зүйл

4.1.Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохицуулах үүрэггүйцэтгэхдээ ашиглана.

4.2.Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг ашигласан тохиолдол бүрт тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд аль байгууллагын ямар дүрс бичлэгийн техник, хэрэгслийг ямар зорилгоор ашигласан, мэдээлэл бичигдсан огноо, цаг, минут, багтаамж, мэдээллийг авсан этгээдийн албан тушаал, овог, нэр, хувийн дугаарыг заавал тусгана.Тэмдэглэлийг тухайн хяналт хийлгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцаж, тоног төхөөрөмжийн бүртгэлтэй техникийн дэвтэрхөтөлнө.

4.3.Төхөөрөмжийн мэдээлэл нь хэрэг зөрчлийн шинжтэй, дахин ашиглах хэрэгцээ шаардлагатай бол хэрэгт хавсаргах нэг хувийг дахин бичих боломжгүй мэдээлэл зөөвөрлөх хэрэгсэлд /DVD-R/ болон тухай байгууллагын төв сервер компьютерт давхар хадгалагана.

4.4.Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хяналтын төхөөрөмжийн мэдээллийг дараах хэлбэрээр ашиглаж болно:

4.4.1.мэдээллийг харилцан солилцох;

4.4.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор сэрэмжүүлэг мэдээлэл бэлтгэх;

4.4.3.сургалтанд ашиглах;

4.5.Мэдээллийг хадгалах, хуулбарлах, олшруулах үед мэдээллийн аюулгүй байдал,нууцлалыгхангахаргахэмжээгзаавалавна.

4.6.Эрх бүхий албан тушаалтан дүрс бичлэгийн техник, хэрэгслийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалалт, хамгаалалтандхяналттавина.

4.7.Дүрс бичлэгийн техник, хэрэгслийнашиглалт, хадгалалт, хэрэглэхдадлагачадварэзэмшүүлэхсургалтыгтогтмолзохионбайгуулна.

4.8.Дүрс бичлэгийн техник, хэрэгслийг ашиглаж байгаа этгээдэддор дүрдсан зүйлийг хориглоно:

4.8.1.телехяналтын системд хандах, давуу эрхийг хязгаарлах, хандалтыг таслах, тоног төхөөрөмжийн холболт, тохиргоог өөрчлөх;

4.8.2.камер, бичлэгийн тоног төхөөрөмжийн сүлжээний хаягжилтыг өөрчлөх, зөвшөөрөлгүй иргэнээр хандалт тохируулах;

4.8.3.нэгдсэн сүлжээнд камер, бичлэгийн төхөөрөмжөөс бусад сүлжээний тоног төхөөрөмжийг залгах.

Тав.Бусад

5.1.Мэдээллийг Архивын ерөнхий газрын даргын 2014 оны А/34 дүгээр тушаалаар баталсан “Кино, дуу, дүрсний баримтын хадгалалт, хамгаалалтын заавар”-ын дагуу архивлан, хадгална.

5.2.Мэдээлэлтэй танилцсан эрх бүхий албан тушаалтан албаныболонхувьхүн, байгууллагыннууцыгзадруулахыг хориглоно.

5.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын телехяналтын нэгдсэн сүлжээнд холбуулахаас татгалзахыг хориглоно.